



Би өнөөдөр гэртээ байсан. Босож чадаагүй. Бас хичээлдээ яваагүй. Яагаад гэвэл би их халуурч байна.



Өчигдөр гадаа маш халуун байсан. Би их халууцсан. Тиймээс би 7 зайрмаг идсэн. Бас хүйтэн кола маш их уусан. Тэгээд би өнөөдөр ярьж чадахгүй байна.

Би маш их өлссөн. Тиймээс би 3 бууз, 2 хуушуур, нэг төмсний салат бас шарсан тахианы мах идсэн. Дараа нь хүйтэн ус уусан. Одоо би өвдөж байна.

Би маш их ханиалгаж байна. Тиймээс миний цээж өвдөөд байна.



Би өнөөдөр маш их ажилтай бас завгүй байсан. Тиймээс ус, цай уугаагүй. Одоо юм амрах хэрэгтэй. Бас толгойны эм уух хэрэгтэй.

Би нохойнд хайртай. Гэхдээ би нохойны үсэнд маш их дургүй. Яагаад гэвэл би харшилтай.